



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/21

Мандалговь

Комисс байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 302 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн улсын үзлэг" зохион байгуулах аймгийн салбар комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: А.Ганбат(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: С.Адъяасүрэн(Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн)

Гишүүд: С.Энхжаргал(Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогч)

Н.Сүхбаатар(Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

М.Туяацэцэг(Татварын хэлтсийн дарга)

Ж.Баярсайхан(Татварын хэлтсийн Татварын улсын ахлах байцаагч)

Б.Одонтунгалаг(Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн Улсын бүртгэгч)

Хоёр. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийг 2019 оны 5 дугаар сарын 1-ний дотор Сангийн сайдын 302 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу чанартай явуулах, нэгдсэн дүнд үнэлэлт, дүгнэлт гаргаж тайлан мэдээг Сангийн яаманд хүргүүлэхийг салбар комиссын дарга (А.Ганбат)-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ 488010053